



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 10 өдөр

Дугаар А/17

Булган сум

“Хүүхдийн төлөө зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.2, 17 дугаар зүйлийн 17.1, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хүүхэд хамгааллын чиглэлээр гаргасан бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг хангах, хүүхдийн оролцоотой бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааг хамтран зохион байгуулж ажиллах “Хүүхдийн төлөө зөвлөл”-ийг шинэчлэн байгуулсугай.

2. Хүүхдийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3. Хүүхдийн эрхийн болон хүүхэд хамгааллын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсэгт заасан чиг үүргийг хэрэгжүүлэх, аймгийн бодлого шийдвэртэй уялдуулан ажиллаж, хүүхдийн дуу хоолойг сонсон, олон нийтэд сурталчлан ажиллахыг зөвлөлийн гишүүдэд даалгасугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны А/113 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 2025. оны
01. дүгээр сарын 10-ны/ний өдрийн 1/17 дүгээр
захирамжийн хавсралт

Хүүхдийн төлөө зөвлөлийн бүрэлдэхүүн

Зөвлөлийн дарга:

Аймгийн Засаг дарга

Гишүүд:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн

бодлогын хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн

хэлтсийн дарга

Цагдаагийн газрын дарга

Боловсролын газрын дарга

Эрүүл мэндийн газрын дарга

Онцгой байдлын газрын дарга

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга

Биеийн тамир, спортын газрын дарга

Улсын бүртгэлийн хэлтсийн дарга

Статистикийн хэлтсийн дарга

Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын дарга

Хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөл

Хүүхдийн парламентийн тэргүүн

Хүүхдийн парламентийн дэд тэргүүн

Нарийн бичгийн дарга:

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дарга